



## ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ АЛБАДАН СУРГАЛТЫН ХЭРЭГЖИЛТ

### МОНИТОРИНГИЙН ТУХАЙ

Нээлттэй Нийгэм Форум нь Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын Дархан-Уул аймгийн салбарт “Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хэрэгжилт” сэдвийн хүрээнд мониторинг хийх тэтгэлэг олгосон билээ. Тус мониторингийн хүрээнд Дархан-Уул аймагт гэр бүлийн хүчирхийллийн зөрчил, гэмт хэрэг үйлдэгсдийн зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын сургалт хэрхэн явагдаж байгаад үнэлгээ, дүгнэлт өгөх замаар тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга зам эрэлхийлэх, хуулийн хэрэгжилтийг сайжруулахад шаардлагатай санал зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Мониторингийн дэлгэрэнгүй тайланг [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудаснаас үзнэ үү.

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ГБХТТХ	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ТББ	Төрийн бус байгууллага
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЦГ	Цагдаагийн газар
ГБХ	Гэр бүлийн хүчирхийлэл
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл

### МОНИТОРИНГИЙН АРГА ЗҮЙ

Бодлогын баримт бичгүүд, түүний хэрэгжилт, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд ажиглалт, туршилт хийх арга зүйг ашиглан мэдээлэл цуглууллаа.

### МОНИТОРИНГИЙН ДҮН

- Мониторингийн хүрээнд зан үйлд нөлөөлөх сургалтыг хариуцан зохион байгуулах үүрэгтэй 5, хамтарсан багийн 7, сургалт зохион явуулдаг ТББ-ын 3, хуулиар холбогдох үүрэг хүлээсэн салбар бүрийн 30 мэргэжилтэн, хүчирхийлэл үйлдэгч 10, хохирогч 10, нийт 65 хүнээс мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийлээ.

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (ГБХТТХ)-ийн томоохон өөрчлөлтийн нэг нь гэр бүлийн хүчирхийллийг иргэний эрх зүйн маргаан бус гэмт хэрэг, зөрчил хэмээн хуульчилж зөрчил, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдахыг шүүхээс даалгахаар хуульчилсан.
- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг Хууль зүй дотоод хэрэг (ХЗДХ)-ийн Сайдын 2017 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн А/73 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна.
- Харин хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журмыг ХЗДХ-ийн Сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын А/63, А/48, А/106 дугаар хамтарсан тушаалаар 2017 оны 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан.
- Гэмт хэргийн статистикаас үзэхэд Дархан-Уул аймагт гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 2019 оны эхний 4 сард буурсан байгаа нь хуулийн сурталчилгаа сайжирч, иргэдийн мэдлэг, мэдээлэл дээшилсэнтэй холбоотой гэж үзэж болох юм.

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ, 44 ДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗАН ҮЙЛД НӨЛӨӨЛӨХ СУРГАЛТ

44.1. Гэр бүлийн зөрчилдөөнтэй асуудлыг хүч хэрэглэхгүйгээр шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалт нь албадан болон сайн дурын хэлбэртэй байна.

44.2. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг энэ чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага хэрэгжүүлж болно.

44.3. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн, нийгмийн хамгааллын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.


44.4. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг хорих ял шийтгүүлсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, баривчлах, албадан сургалтад хамруулах шийтгэл хүлээсэн этгээдэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх, цагдаагийн байгууллага зохион байгуулна.

44.5. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж заасан.

### Хүснэгт 1. Зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын сургалт явуулах эрх зүйн орчин

№	Чиг үүрэг	Үүрэг хүлээсэн байгууллага	Эрх зүйн заалт	Санхүүжилт
1	Зан үйлд нөлөөлөх албадан сургалт явуулах	ЦГ ШШГГ	ГБХТТХ-ийн 44.4, Зөрчлийн тухай хуулийн 4.5 , 5.4 Эрүүгийн хуулийн 7.3.2.2 Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр журам ХЗДХ-ийн сайдын 2017.04.04 А/73 дугаар тушаал	Тухайн байгууллага хариуцна. Хөтөлбөрийн 10.1-д зааснаар улсын төсөв, төрийн болон төрийн бус байгууллагын санхүүжилт, байгууллагын дотоод орлого
2	Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалт явуулах	Төрийн бус байгууллага Аймаг нийслэлийн Засаг дарга, ИТХ-ын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга нь хяналт тавьж, дэмжлэг үзүүлнэ.	ГБХТТХ-ийн 44.4 ХЗДХС, ХНХС, ЭМС-ын хамтарсан тушаал 2017.03.22 А/63, А/48, А/106	Шаардагдах зардлыг оролцогч өөрөө гаргана. Хөтөлбөр журмын 6.1

**График 1. Дархан-Уул аймгийн Сум дундын анхан шатны Эрүүгийн хэргийн шүүхээр шийдэгдсэн ГБХ-ийн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээллээс...**



- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар сэтгэл зүйчтэй бөгөөд мэргэшүүлэх сургалтад нэг удаа хамрагджээ. Сургалтын анги танхим, тоног төхөөрөмжөөр хангагдсан, сургалт явуулах тусгай төлөвлөгөөтэй зэрэгцээ хүн тус бүрд тохируулан хөтөлбөр гаргаж, сургалтад оролцсон хүмүүст тараах материал өгдөг байна. Анхаарах зүйл бол нэгдсэн аргачлал байхгүй, гарын авлага дутагдалтай. Сэтгэл зүйч нь “Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнгийн гарын авлагыг удирдамж болгон ажиллаж байна. Мөн сургалтад зориулсан нэмэлт төсөвгүй байгаа нь хүндрэл учруулдаг ажээ. Гагцхүү оролцогчид өөр ажилд дайчлагдсан байх үед хуваарьт сургалтад хамрагдаж чаддаггүй тул дараа нь тусгайлан нөхөж сургадаг байна. Сургалтад хамрагдсан иргэнийг хорихоос суллагдсаны дараа сургалтын үр дүнг тодорхойлох ямарваа судалгаа, үнэлгээ хийгддэггүй.
- Цагдаагийн газар нь зан үйлд нөлөөлөх сургалтад зориулсан танхим, орчин, бэлтгэгдсэн сургагч багш байхгүй бөгөөд урьдчилан сэргийлэх ажил хариуцсан алба хаагч сургалт зохион байгуулах үүрэгтэй. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албаны ажилтнууд урьдчилан сэргийлэх сургалтуудыг нийтэд зориулж амжилттай хийдэг хэдий ч зан үйлд нөлөөлөх сургалт явуулах чиглэлээр

мэргэшээгүй нь учир дутагдалтай байна. Мөн ажлын ачааллаас шалтгаалан хүн нэг бүртэй тулж ажиллах цаг, боломжгүй. Үүний зэрэгцээ баривчлах байрны орчин нөхцөл хүнд, сургалт явуулах боломжгүй тул сургалт нэр төдий явагддаг байна. Мөн санхүүгийн асуудал шийдэгдээгүй тул ТББ-д тулгуурлан явуулж байна.

- ГБХЗХГ-т сургалтын хэрэглэгдэхүүн, танхим байгаа хэдий ч тусгай хөтөлбөр, бэлтгэгдсэн сургагч багшгүй байна. Тус байгууллага нь Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасны дагуу хорихоос өөр төрлийн ял эдэлж байгаа насанд хүрээгүй холбогдогчдод хүмүүжил, төлөвшлийн үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн.
- Бусад гэдэгт ТББ-ууд орж байгаа хэдий ч зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах ТББ-ыг магадлан итгэмжлэх асуудал шийдэгдээгүй байгаа болно.
- Дархан-Уул аймгийн хувьд “Шинэ амьдралын эхлэл” ТББ ШШГГ болон ЦГ-тай зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах асуудлаар гэрээтэй ажилладаг байна. ШШГГ нь тусгай танхимтай тул очиж сургалтаа явуулдаг. ЦГ-ын дэргэдэх баривчлах байр нь сургалт явуулах орчин бүрдээгүй тул мэдээлэл өгөх байдлаар баривчлагсадтай уулздаг ажээ. Баривчлагдсан хүмүүс хэрэв

хүсвэл суллагдсаны дараа тус төвд очиж тусгай хөтөлбөртэй сургалтад суудаг байна. Ихэвчлэн архины хамааралтай хүмүүсийн зан үйлд нөлөөлөх сургалт явуулдаг бөгөөд үр дүнд нь 1-2 хүн архинаас гарчээ. Харин “Аз жаргалын эрэлд” ТББ-ын санхүүжилт тогтворгүйн улмаас үйл ажиллагаа нь зогсонги байдалд байна.

- ХЭҮТ-ийн Дархан салбар 2019 онд зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг нийт 20 хүнийг хамруулан тусгай хөтөлбөрөөр сарын хугацаанд туршлаа. Туршилтын үр дүнд дараах дүгнэлтийг хийлээ.
  - Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын анхан шатанд бүлгээр сургалт зохион байгуулах боломжгүй. Учир нь шүүхээс Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйлд заасны дагуу 7-30 хоног баривчлахад 10-50 цагийн сургалтад суухыг даалгадаг. Шүүхийн шийдвэрээс харахад зөрчил гаргагчдын 70 хувь нь 7 хоногийн баривчлагдах шийтгэлтэй байсан бөгөөд 10 цагийн зан үйлд нөлөөлөх сургалтад суухаар шийдэгджээ. Харин үлдсэн 30 хувь нь 21-30 хоног баривчлагдах, 15 цагийн сургалтад хамрагдах шийтгэвэртэй байв. Гэтэл ХЗДХ-ийн Сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан хөтөлбөрт нэг хүний зан үйлд нөлөөлөх сургалт 23-56 цаг үргэлжлэхээр заажээ. Нэг удаагийн сургалтад дунджаар 6 хүн
  - Шинэ сургалт эхлэх бүрд оролцогч солигддог учраас урьдчилсан үнэлгээ хийх, шинэ мэдлэг олгох ажил дахин давтагддаг. Мөн оролцогчдын 20 хувь нь бичиг үсэгт тайлагдаагүй гарын үсэг зурах төдий боловсролтой иргэд байгаагаас багшаас нэмэлт ур чадвар шаардаж байна.
  - Шүүхийн шийтгэврийн хугацаа дуусахад оролцогчийг сайн дурын сургалтад хамрагдахыг санал болгодог ч тэд өөрчлөлтийг мэдрэх хэмжээнд сургалт авч чадаагүй тул саналаараа ирдэггүй, мөн амьжиргаагаа залгуулах үүднээс гэрээсээ хол ажиллах нь их байна.
  - 6-8 цагийн сургалтад оролцсон хүмүүсийн 15 хувь нь гэр бүлийн гишүүдээ зан үйлд нөлөөлөх сургалтад суухыг санал болгосон нь сургалт хэрэгцээтэй болохыг харуулж байна. Мөн хүн бүрт чиглэсэн хөтөлбөр гаргаж, урт хугацаанд, тасралтгүй явуулж байж эерэг үр дүн гарах боломжтой.

Манай нөхөр баривчлагдаад байхдаа танай сургалтад суусан, их зүйл ойлгосон, бид хүүхэдтэйгээ маш буруу харьцаж байсан байна, чи заавал очиж суугаарай, хоёулаа өөрсдийгөө өөрчилье, хүүгээ ч өөрсдөдөө татаж авъя гэж ярьсан.

*Зан үйлд нөлөөлөх сургалтад сайн дураараа ирсэн эмэгтэйн ярианаас...*

Хөдөө сумдад гэр бүлийн хүчирхийлэлд хамаарах зорилтот бүлгийнхэнтэй уулзахад, “Бидэнтэй хэн ч ингэж ярилцаж байгаагүй, энэ чинь манай нөхөрт маш хэрэгтэй сургалт байна, та нар сард 1 удаа ирээд уулзалт – сургалт хийж байгаач” гэсэн хүсэлт тавьж байлаа.

*ХЭҮТ-ийн Дархан салбарын эрх зүйчийн ярианаас...*

- Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж, зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан 10 оролцогчоос ярилцлагын аргаар судалгаа авлаа. Оролцогчид харилцан адилгүй боловсролтой бөгөөд албадан сургалтын агуулга, ач холбогдлын талаар ойлголтгүй байлаа.
  - Оролцогчдын 50 хувь нь 35-39 насны эрэгтэйчүүд байсан бөгөөд 90 хувь нь зан үйлд нөлөөлөх албадан сургалтад дөрвөөс дээш удаа хамрагджээ.
  - Шүүхийн шийтгэвэрт заасан хугацааны сургалтад баривчлагдсан үедээ бүрэн хамрагдаж чадаагүй бөгөөд сургалтын төлөвлөгөөтэй нийт оролцогчдын 60 хувь танилцаагүй байна.
  - Мөн 60 хувь нь сургалтын хөтөлбөртөө дунд зэрэг үнэлгээ өгсөн бол үлдсэн 40 хувь нь сургалтыг хангалтгүй гэж дүгнэжээ.
  - Сургалт явуулах нөхцөл бүрдээгүй орчинд 1, 2 хүн ирээд бараг цаг хүрэхгүй хугацаанд уулзаж, нэг талаас чиглэсэн мэдээлэл өгөхийг сургалт хэмээн хүлээн авч байна. Сургалт оролцоонд тулгуурлахгүй байна.
  - Оролцогчдын 80 хувь нь зохион байгуулалт тааруу, уйтгартай, сонирхолгүй гэсэн бол, 60 хувь нь сэдэв, агуулга оновчгүй, сургалтын тоо, давтамж хэт цөөн, сургагч багшийн мэдлэг, чадварыг тааруу гэж үнэлжээ.
- Нийт оролцогч сургалтын төлөвлөгөөг танилцуулах, сургалтыг хүргэх арга хэлбэрийг нэмэгдүүлэх, сэдэв, агуулгыг сайжруулах шаардлагатай гэсэн бол 60 хувь нь сургагч багшийг чадавхжуулах, 40 хувь нь сургагч багшийг солих шаардлагатай гэж үзжээ. Тэд сургалтын танхим, орчин, талбай, сургалтын хэрэглэгдэхүүн хангалтгүй гэсэн бол сургалтад сууснаар хууль эрх зүйн мэдлэг, тэр дундаа гэр бүлийн хүчирхийллийг 3 дахин давтан үйлдвэл шоронд сууна гэдгээ мэдэж авсан хэмээн хариулжээ.
- Сургалтыг үр дүнд хүргэхийн тулд гэр бүлийн гишүүдийг сургалтад суулгах, эрэгтэй, эмэгтэйгээр нь салгаж сургалт зохион байгуулах, өсвөр насны хүүхдүүдэд эцэг, эхээ хүндэлдэг, үгийг нь сонсдог байхыг сургах, ганцаарчилсан зөвлөгөө авах боломжоор хангах, сургалтын танхим, орчныг бүрдүүлэх, багийн нийгмийн ажилтныг тусдаа өрөөтэй болгох хэрэгтэй гэж үзжээ.

### Хохирогч эмэгтэйчүүдтэй ярилцсан тэмдэглэлээс...

- Өөрчлөлт гардаг бол сайхан л байна. Төрөлхийн хатуу харгис ийм хүн ямар ч сургалтад суугаад засрахгүй байх аа. 2015 онд эрх хязгаарлуулж байсан, 2019 оны 4-р сард 7 хоног, 5-р сард 30 хоног баривчлуулсан. Одоо салахаас өөр зам үлдсэнгүй дээ.
 

*43 настай эмэгтэйн ярианаас...*
- Сургалтыг олон хүнд, энэ архи уудаг залууст тогтмол хийж заншвал үр дүн гарна. Өөрсдөө сайн дураараа очихгүй ээ, иймээс албадах л хэрэгтэй.
 

*52 настай эмэгтэйн ярианаас...*
- Манай нөхөр 2 удаа баривчлагдсан, 1 удаад нь хүүхдийнхээ гарыг хугалаад 1 жилээр хоригдсон. Засарсан, ажиглагдах том өөрчлөлт гараагүй. Архи ууж агсам тавьдаг нь л жаахан багассан.
 

*28 настай 7 хүүхэдтэй эмэгтэйн ярианаас...*
- Нөхөр маань баривчлагдаад сургалтад суугаад их зүйл ойлгосон байсан. Энэ сургалтад гэр бүлээрээ хамрагдаж, тасралтгүй явж амьдралаа сайхан болгох хүсэл байна. Нөхөртэй, надтай, хүүхэдтэй минь ажиллаад нөлөөлөөд өгөөч.
 

*38 настай 3 хүүхэдтэй эмэгтэйн ярианаас...*

- Манай нөхөр хүчирхийлэл үйлдэж сүйд болоогүй, архи уухаар нь би өөрөө л уурандаа муужирч унасан. Аав маань цагдаа дуудаад тэгээд л манай нөхөр 7 хоног баривчлагдсан. Тэгдэг гэж бодоо ч үгүй байсан. Тэнд ямар ч сургалт явагдаагүй гэсэн.

*24 настай эмэгтэйн ярианаас...*

- Нөхөр маань ааш гаргадаг ч би нөхөртөө хайртай, хүүхдүүдээ эцэггүй өсгөхийг хүсэхгүй байна. Цагдаа дуудахдаа ийм юм болно, баривчилдаг гэж бодоогүй. Нөхөрт маань сайн ойлгуулаад өгдөг бол сайн л байна. Ийм сургалт байдаг гэж мэдээгүй, би өөрөө ч, нөхрөө ч суулгамаар байна. Нөхөр маань ажил хийх гээд хот явсан. Одоо сууж чадахгүй л дээ.

*35 настай эмэгтэйн ярианаас...*

- Нөхрийн ярьснаар бол эхнэрүүд бид бас суух хэрэгтэй гэсэн. Хуулиар заасан тэр цаг хугацаанд нь сургалтыг чанартай явуулбал хэрэгтэй, тэр хүмүүс нэлээд ухаарлыг олж авах байх гэж бодож байна. Зөрчлийн тухай хуульд 2 хүнийг хоёуланг нь сургалтад суулгах заалт оруулбал тохирно гэж манай нөхөр яриад байгаа.

*36 настай эмэгтэйн ярианаас...*

## МОНИТОРИНГИЙН ДҮГНЭЛТ

- Аймгийн ГБХЗХГ, ЦГ-ын үүрэг хүлээсэн мэргэжилтнүүд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хууль сурталчлах, мэдээлэл өгөх чиглэлээр боломжийн түвшинд ажиллаж байна.
- Зарим хамтарсан багийн гишүүн, багийн зохион байгуулагч гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, тэдний гэр бүлийн гишүүдтэй ганцаарчилсан уулзалт хийж, зөвлөгөө өгч хэвшсэнээр хүчирхийллийн харилцааг өөрчилсөн сайн туршлага байна.
- Харин хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх албадан сургалт нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын нэг төрөл болж хуульчлагдсан хэдий ч хэрэгжилт туйлын хангалтгүй байна.
- Зөрчлийн тухай хуулийн 5.4-т албадан сургалтыг 10-50 цаг байхаар заасантай ХЗДХ-ийн Сайдын тушаалаар баталсан хөтөлбөрийн хугацаа зөрчилдөж байна. Шүүхийн практикаас үзэхэд 7 хоногийн баривчилгаанд 10, 14 хоногийн баривчилгаанд 10, 21-30 хоногийн баривчилгаанд 15 цагийн сургалтад тус тус суухыг даалгаж байна. Гэтэл энэ нь тухайн хүний зан үйлд эерэг хандлага төлөвшүүлэхэд хангалттай хугацаа биш юм.
- Албадан сургалт явуулах журмаар сургалтын хөтөлбөрийн агуулга, чиглэлийг хэт ерөнхий зохицуулснаас гадна орон нутаг бүрт ялгаатай байдлаар явуулах нөхцөл бүрдүүлсэн нь хууль нэг мөр хэрэгжих боломжийг алдагдуулах, сургалтад ач холбогдол өгөхгүй ёс төдий хандах, мэргэшсэн бус ТББ-ын төлөөллийг гэрээлэн оролцуулах зэргээр хуулийн дагуу хүлээлгэх хариуцлага гэхээс илүүтэй мэдээлэл өгөх үйл ажиллагаатай адилтган хэрэгжүүлж байна.
- Сайн дурын сургалтын хөтөлбөр, журам байгаа хэдий ч түүнийг хэрэгжүүлэх тал дээр хуулиар үүрэг хүлээсэн алба хаагчид санаачилга гаргаж, шаардлага тавих нь сул, хамтарсан багийн гишүүд ч энэ талаар ойлголт үгүй, мөн иргэд сайн дурын үндсэн дээр зардлаа өөрсдөө хариуцаж, сургалтад хамрагдахыг ойлгохгүй, хүсэхгүй байна.
- Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга бөгөөд ГХУСАЗСЗ-ийн дарга нь Зан үйлд

нөлөөлөх сайн дурын сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, дэмжлэг үзүүлнэ хэмээн 3 сайдын хамтарсан тушаалаар баталсан журамд заасан хэдий ч энэ үйл ажиллагаа хэрэгждэггүй. Удирдах албан тушаалтнууд зөвхөн урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийн үйл ажиллагаанд л анхаарал тавьсан байдалтай байна.

- Хөтөлбөрт зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг ГБХТТХ-ийн 44.2-т заасан ТББ хариуцна гэсэн ч төрөөс магадлан итгэмжлэх асуудлыг шийдвэрлээгүйн улмаас хариуцах ТББ байхгүй байна.

- Зан үйлд нөлөөлөх албадан болон сайн дурын сургалтыг хөтлөн явуулах алба хаагчдыг мэргэшүүлээгүй, хандлагын өөрчлөлт бий болгоогүй нөхцөлд хуулийн энэ заалт хэрэгжих боломжгүй байна.

- ГБХЗХГ-т хүүхдийн зан үйл, хүмүүжил төлөвшилд нөлөөлөх ажлыг хуульчлан хариуцуулсан учир шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас уг ажлыг даалгадаг. Харин насанд хүрэгчдийн зан үйлд нөлөөлөх ажлыг уг газарт хамаатуулсан эрх зүйн баримт бичиг байхгүй байна.

## ЗӨВЛӨМЖ

### **ХУУЛЬ ЗҮЙ ДОТООД ХЭРГИЙН ЯАМАНД:**

1. ХЗДХ-ийн Сайдын 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журмыг сайжруулах, сургагч багш бэлтгэх, хүний нөөц бүрдүүлэх, үндэсний хэмжээнд нэгдсэн стандартаар хэрэгжүүлэх нөхцөлийг хангах;
2. Зөрчлийн тухай хуулийн 4.5 дугаар зүйлийн 3-т заасан албадан сургалт нь 10-50 цагийн хугацаатай байна гэсэн заалт, одоо мөрдөгдөж байгаа зан үйлд нөлөөлөх албадан сургалтын хөтөлбөр, журамд сургалтын нийт үргэлжлэх хугацаа 23-56 цаг байна гэсэн заалттай зөрчилдөж байгааг залруулж нэг мөр болгох;
3. Сайн дурын сургалтыг хариуцан явуулах ТББ-ыг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулах, магадлан итгэмжлэлийг явуулж, хамтран ажиллах хөтөлбөр хэрэгжүүлэх.

### **ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ БОЛОН ЗАСАГ ДАРГАД:**

1. ГБХТТХ-ийн 12.1.2-т заасан ГБХ-тэй тэмцэх асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, чиглэл өгөх, хяналт тавих үүргээ хэрэгжүүлэхдээ Зан үйлд нөлөөлөх сургалтын үйл ажиллагаанд анхаарах;
2. Албадан сургалтын журмын 10.1.1-д заасан санхүүжилтийн эх үүсвэрийг дараа оны орон нутгийн төсөвт заавал тусгаж баталж байх;
3. Хамтарсан багт журмын дагуу тодорхой санхүүжилт зориулалтаар нь олгох;
4. Сургалт явуулах шаардлага хангасан орчин бүрдүүлэхийн тулд ЦГ-ын дэргэдэх баривчлах байрны хөрөнгө санхүүгийн асуудлыг ИТХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх.

### **ЦАГДААГИЙН ГАЗАР БОЛОН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАРТ:**

1. Зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамрагдсан хүмүүсийн бүртгэл, судалгааны маягыг боловсронгуй болгож хөтлөх, статистик дүн мэдээг ГБХТТХ-д хүлээсэн чиг үүргийн дагуу тодорхой гаргаж хэвших;
2. Сургалтын хэрэгжилт үр дүнд богино хугацааны дүн шинжилгээ хийж анхаарах асуудлыг тодруулж, шаардлагатай үйл ажиллагааг явуулж хэвшүүлэх;
3. Хүн бүрт тохирсон хөтөлбөр гаргаж ажиллах учраас ажлын байр – орон тоог бий болгож, сургалтад хамрагдаж мэргэшсэн эрх бүхий мэргэжлийн хүн ажиллуулах;
4. Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх бол санхүүгийн асуудлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн байх;
5. ГБХ үйлдэгдэж дуудлага ирсэн, хэрэг бүртгэл хийгдсэн тохиолдолд Хамтарсан багт, багийн Засаг даргад мэдэгдэж хэвших.

### **ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗАРТ:**

1. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад иргэдийг хамруулах ажилд илүү анхаарал тавих;
2. Зан үйлд нөлөөлөх сургалтын асуудлаар ТББ-тай гэрээлж ажиллах эрх зүйн нөхцөлийг эргэн харж, боломж нөхцөлийг хангасан холбогдох шийдвэрийг гаргуулах.

### **ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ:**

1. Зан үйлд нөлөөлөх Сайн дурын сургалт явуулахдаа ТББ-тай гэрээлж ажиллах боломжийг эрэлхийлэх;
2. Хамтарсан багийн гишүүд ГБХ үйлдэгчдийн судалгааг нарийвчлан гаргаж, шаардлагатай бол зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдахыг зөвлөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж хэвшүүлэх. Энэ нь ажлын байрны гүйцэтгэлийн нэг үзүүлэлт болох;
3. Багийн нийгмийн ажилтны ажлын өрөөг тусгаарлаж, ганцаарчилсан уулзалт зөвлөгөө өгөх боломжийг олгож өгөх;
4. Хамтарсан багийн үйл ажиллагаанд болон зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад зориулсан зардлын асуудлыг шийдвэрлэх.

### **ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАД:**

1. Сургалт явуулах тогтсон хөтөлбөр төлөвлөгөөтэй, мэргэшсэн хүний нөөцтэй, үйл ажиллагаа нь ил тод байх;
2. Зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтад иргэдийг хамруулах тал дээр хамтарсан багууд, холбогдох байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтын ажиллагаагаа сайжруулах.